

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Засгийн газрын болон салбарын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, төлөвлөлт нь хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн түвшингээр тодорхойлж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргаж удирдлага болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Үндэсний хөгжлийн газарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, газрын 2018 оны IV улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл болон тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, үр дүнг нотлох холбогдох материалуудыг ашиглан гүйцэтгэсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А-25 тоот “Төлөвлөгөө батлах тухай” тушаалаар Бодлогын баримт бичигт тусгагдсан 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр болон Үндэсний хөтөлбөрт туссан Үндэсний хөгжлийн газрын хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр заасан зорилт, арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлж ажиллах хэлтэс, албаар нь гарган батлуулсан.

Тушаалын нэгдүгээр хавсралтаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 57 зорилт, арга хэмжээг, хоёрдугаар хавсралтаар эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд туссан 7 зорилт, арга хэмжээ, тушаалын гуравдугаар хавсралтаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 12 зорилт, арга хэмжээ, дөрөвдүгээр хавсралтаар Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 6 үндэсний хөтөлбөрийг тус тус батласан бөгөөд биелэлтийг хагас болон бүтэн жилээр тооцон ажилласан.

2018 оны жилийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтээс журмын дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр болон хууль тогтоомжийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем болох www.unelgee.gov.mn-д хугацаанд нь байршуулж баталгаажуулсан бөгөөд хэрэгжилтийг хувиар харуулахад:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр – 67.2%
2. Эдийн засгийг сэргээх хөтөлбөр – 58.8%
3. Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл - үнэлгээгүй
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр – 80.2%
5. Үндэсний хөтөлбөр - үнэлгээгүй
6. Гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл – 100% тус тус үнэлэгдсэн.


1.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2016-2020 он

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого”, “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого”, “Нийгмийн бодлого”, “Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого”, “Засаглалын бодлого”, “Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтууд”-ын хүрээнд Үндэсний хөгжлийн газрын Хариуцан хэрэгжүүлэх 19, Хамтран хэрэгжүүлэх 38 арга хэмжээ тусгагдсан.

2018 оны эхний хагас жилийн байдлаар Үндсэн хэрэгжүүлэх 4 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 1, 40 хувийн биелэлттэй 2, 0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Дундаж үнэлгээгээр 45 хувийн биелэлттэй, холбогдох байгууллагатай хамтран Үндсэн хэрэгжүүлэх нийтдээ 19 /өмнөх 4 арга хэмжээ багтсан/ арга хэмжээ байгаа бөгөөд 100 хувийн биелэлттэй 3, 70 хувийн биелэлттэй 2, 40 хувийн биелэлттэй 10, 0 хувийн биелэлттэй 3, Үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Дундаж үнэлгээгээр 46.66 хувь байна.

Жилийн эцсийн байдлаар үндсэн хэрэгжүүлэх 4 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй 3, 0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ, дундаж үнэлгээгээр 75 хувийн биелэлттэй байна. Холбогдох төрийн байгууллагатай хамтран үндсэн хэрэгжүүлэх нийт 19 /өмнөх 4 арга хэмжээ багтсан/ арга хэмжээ байгаа бөгөөд 100 хувийн биелэлттэй 8, 70 хувийн биелэлттэй 3, 40 хувийн биелэлттэй 5, 0 хувийн биелэлттэй 2, Үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ, дундаж үнэлгээгээр 67.2 хувьтай үнэлэгдсэн.

Эхний хагас жилийн биелэлтийг жилийн эцсийн үнэлгээтэй харьцуулахад биелэлт 20.5 хувиар өссөн байна.



1.2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Үндэсний хөгжлийн газар хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ тусаагүй тул үнэлээгүй бөгөөд хамтран хэрэгжүүлэх 12 арга хэмжээний биелэлтийг гарган хүргүүлсэн. Үүнд:

- Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ,

- Хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд 4 арга хэмжээ,

- Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих зохилт арга хэмжээ,

Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд 6 арга хэмжээний биелэлтийг тайлагнасан.

1.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны тайланг журмын 6.3-т заасан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилтийг эрх зүйн акт батлагдсанаас хойш хийгдсэн ажлын үр дүнгийн өссөн дүнгээр тооцож гаргасан.

2018 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад авсан нийт 48 эрх зүйн актын 65 зүйл, заалтаас Монгол Улсын хууль 6, Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын тогтоол 35, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 15, ҮАБЗ-ийн зөвлөмж 1, Засгийн газрын албан даалгавар 7 байна. Үүнд шийдвэрийн зүйл, заалт тус бүрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр бүрэн хэрэгжсэн 100 хувийн биелэлттэй-28, хэрэгжих шатанд 70 хувийн биелэлттэй-13, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн биелэлттэй-15, хэрэгжээгүй 0 хувийн биелэлттэй-1 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 8 зүйл, заалт байгаа бөгөөд дундаж үнэлгээгээр 72.98 хувьтай үнэлэгдсэн.

2018 оны жилийн эцсийн байдлаар 98 эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнасан ба газрын хэмжээнд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 80.23 хувьтай үнэлэгдсэн. Хэрэгжилт тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, нэг удаагийн шинжтэй биелэгдсэн 25 тогтоол шийдвэрийг хяналтаас хасах саналтайгаар хүргүүлсэн бөгөөд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 48 заалт, хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй 24 заалт, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн биелэлттэй 14 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 12 заалт байна.

- Монгол Улсын Хууль, тогтоомж болох Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 зүйл заалтаас бүрэн хэрэгжсэн буюу

100%-тай 1, хэрэгжих шатандаа буюу 70%-тай 3, хэрэгжилтийн хугацаа болоогүй 2, биелэлт дундажаар 77.5 хувьтай;

- Ерөнхийлөгчийн зарлиг 2 шийдвэрлэлт хэрэгжилт 100 хувьтай;
- Засгийн газрын тогтоол хяналтад авсан 36 шийдвэрийн 53 зүйл заалтаас 25 нь бүрэн хэрэгжсэн буюу 100%, хэрэгжих шатандаа буюу 70%-тай 11, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-тай 9, заалтийн хэрэгжилтийн хугацаа болоогүй 8, биелэлт дундажаар 78,7 хувьтай;
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл хяналтад авсан 22 шийдвэрийн 25 зүйл заалтаас бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 13, хэрэгжих шатандаа буюу 70%-тай 5, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-тай 5, хэрэгжилтийн хугацаа болоогүй 2, биелэлт дундажаар 78,3 хувьтай;
- Засгийн газрын албан даалгавар хяналтад авсан 1 шийдвэрийн 7 зүйл заалтаас бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 6, хэрэгжих шатандаа буюу 70%-тай 1, биелэлт дундажаар 95,7 хувьтай;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж хяналтад авсан 1 зүйл заалт бүрэн хэрэгжсэн 100 хувьтай;
- Ерөнхий сайдын захирамж 4 хэрэгжих шатандаа 70 хувьтай үнэлэгдсэн байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ үнэлгээний цахим мэдээллийн сан /unelgee.gov.mn/-д Үндэсний хөгжлийн газраас 2018 оны жилийн эцэст 98 эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнахаар заасан.

1.4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтад Үндэсний хөгжлийн газрын үндсэн хэрэгжүүлэх 3 хөтөлбөр /Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Зөгийн үүр хөтөлбөр, Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөр/, хамтран хэрэгжүүлэх 2 хөтөлбөр /Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр, Хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр/, оролцон хэрэгжүүлэх 1 хөтөлбөр /Монгол экспорт хөтөлбөр/-үүд багтсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 11.4, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Үндэсний хөгжлийн газраас Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр холбогдох яам, агентлагуудад албан тоотуудыг хүргүүлсэн. Яам, агентлагуудаас тайланг хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2019 оны I дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.

Мөн “Үйлдвэржилт 21:100” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилт 3.1-ийн хүрээнд “Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийг байгуулах”, зорилт 5.9-ийн хүрээнд “Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдааны түнш орнуудад сурталчлах ЭКСПО-г зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх”, зорилт 5.11-ийн хүрээнд “Үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх худалдааны нэгдсэн портал сайт, аппликейшн бий болгох” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй /2019-2020/, “Зөгийн үүр” хөтөлбөр санхүүжилт байхгүйгээс хэрэгжээгүй

бөгөөд хэрэгжих хугацаа нь дууссан, "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" хөтөлбөр санхүүжилт байхгүйгээс хэрэгжээгүй, бусад хөтөлбөр хэрэгжилт эхлэх шатандаа явж байгаа тул дээрх Үндэсний хөтөлбөрүүдийн явцын мэдээллийг ЗГХЭГ-д хүргүүлсэн.

1.5.Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт

2018 онд тус газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс гадаадын буцалтгүй тусламжаар 3 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд төслийн нийт санхүүжилт 164.3 сая төгрөг байна.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх нь" үндсэн төслийн хүрээнд эхний хэрэгжүүлэх төсөл "Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх замаар дунд хугацааны хөгжлийн хүрээ боловсруулах /санхүүжилт 87.8 сая төгрөг/, дараагийн төсөл болох "Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон дунд хугацаанд буюу 2020-2025 онд хангах Дунд хугацааны хөгжлийн хүрээний төслийг боловсруулахад шаардлагатай хэлэлцүүлэг зохион байгуулах болон Үндэсний сайн дурын тайлангийн бэлтгэл ажлыг хангах" /санхүүжилт 64.8 сая төгрөг/, "Парис 21" байгууллагаас санхүүжүүлсэн "ADAPT арга хэрэгслийн талаар олон талыг хамарсан сургалт, семинар зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх" төсөл /санхүүжилт 11.8 сая төгрөг/-ийг тус тус хэрэгжүүлсэн.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр болон Үндэсний хөгжлийн газар хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх нь" төслийн хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдөр харилцан тохирсон тухай захидалд 2 тал гарын үсэг зурсан бөгөөд санхүүжилтийг НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлсэн байна. Төслийн хүрээнд 2018 оны үндсэн зорилт болох дунд хугацааны хөгжлийн хүрээ боловсруулах ажил хийгдэж дууссан байна.

"Монгол Улсад Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх нь" төслийн хүрээнд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон дунд хугацаанд буюу 2020-2025 онд хангах Дунд хугацааны хөгжлийн хүрээний төслийг боловсруулахад шаардлагатай хэлэлцүүлэг зохион байгуулах болон Үндэсний сайн дурын тайлангийн бэлтгэл ажлыг хангах төслийн хүрээнд 3 зорилт тавин хэрэгжүүлсэн байна.

Ахисан түвшний статистик тоо мэдээг төлөвлөхөд зориулагдсан ADAPT арга хэрэгслийн талаар олон талыг хамарсан сургалт, семинар зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөл нь "Парис 21" байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн. Төслийн үндсэн зорилгын хүрээнд Газрын даргын А-151 тушаалаар ахисан түвшний статистик тоо мэдээг төлөвлөхөд зориулагдсан ADAPT арга хэрэгслийн шинэчилсэн хувилбарыг танилцуулах сургалтыг Үндэсний статистикийн

хороотой хамтран статистик тоо мэдээ гаргадаг талуудын төлөөлөлд зохион байгуулсан.

Цаашид буцалтгүй тусламжаар хэрэгжих төслийн гэрээнд бичиг хэргийн зардлыг суулгаж өгөх тал дээр анхаарах мөн төслийн санхүүгийн анхан шатны баримтыг тухай бүрд нь санхүүд бүрдүүлж өгөх, төслийн үр дүнгийн талаарх тайлан, зарцуулалтын тайланг санхүүд гарган өгдөг байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дундаж үнэлгээгээр дээрх төслүүд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн буюу 100 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн.

1.6.Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилт

2018 оны эхний хагас жилийн байдлаар Үндсэн хэрэгжүүлэх 4 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ тусгагдсанаас үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй 2, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн биелэлттэй 1, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ байна. Дундаж үнэлгээгээр 58.8 хувьтай дүгнэгдсэн.

2. ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт

Газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 стратеги зорилтын хүрээнд 18 зорилт, 207 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 болон 6.7 заалтын дагуу хийж гүйцэтгэсэн.


Газрын төлөвлөгөөний биелэлтэд хагас жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

2018 оны эхний хагас жилийн байдлаар газрын нийт албан хаагчдийн үр дүнгийн гэрээ болон гэрээний биелэлтийг гаргуулан авч, гэрээнд орсон ажлууд төлөвлөгөөнд бүрэн туссан эсэх, биелэлтийг бүрэн гаргасан эсэхийг хянаж үзсэн бөгөөд тухайн хэлтэс, албаны ажлын ачаалал жигд хувиарлагдсан эсэх, төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт өгөхийг зорьсон.

Эхний хагас жилийн байдлаар албан хаагчдын үр дүнгийн гэрээний нийт ажил үйлчилгээ буюу газрын төлөвлөгөөнд орсон ажлуудад биелэлт тооцсон.

Төлөвлөгөөнд суусан хугацааны дагуу нийт 186 арга хэмжээнд үнэлгээ хийхэд газрын хэмжээнд эхний хагас жилд дунджаар 72.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд 105 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, 23 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, 44 арга хэмжээ 30 хувийн биелэлттэй, 14 арга хэмжээ биелээгүй буюу 0 хувь байсан.

Жилийн эцсийн байдлаар 5 стратеги зорилтын хүрээнд 18 зорилт, 207 арга хэмжээний хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 89.9 биелэлттэй үнэлэгдсэн ба 162 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, 27 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, 17 арга хэмжээ 30 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 0 үнэлгээтэй дүгнэгдлээ.



Хагас жил болон жилийн эцсийн үнэлгээг харьцуулан харахад 17.7 хувиар өссөн боловч төлөвлөсөн хугацаагаар нь харахад нийт арга хэмжээний 21.7 хувь буюу 45 арга хэмжээ хугацаандаа хийгдээгүй байна. /Тайлан, танилцуулгыг хавсралтаар хүргүүлэв./

2.2 Ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Журмын 3.2.3.4-д заасан захиргааны байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хавсралтын дагуу Төрийн захиргааны удирдлагын газраас авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн үнэлгээтэй үнэлэгдсэн ба хүний нөөцийн ил тод байдал дунджаар 80 хувь үнэлэгдэж, хэрэгжилтийн нийт үнэлгээ 90 хувийн биелэлттэй үнэлэгдсэн.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлт хангалтгүй буюу 30 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд энэ талаар дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.3 Шилэн дансны хөтлөлт

Сангийн яамнаас гаргадаг Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ албан ёсоор ирээгүй байна.

2.4 Шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан

төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.9-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуу Авлигатай тэмцэх газраас 2018 онд төрийн байгууллагуудын “Шударга байдлын үнэлгээ-2018”-г гаргасан байна.

Шударга байдлын үнэлгээ нь Гадаад шударга байдлын үнэлгээ /үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ/, Дотоод шударга байдлын үнэлгээ /төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ/, Бодлогод оролцогчдийн үнэлгээ /Шинжээчдийн үнэлгээ/ гэсэн 3 дэд үнэлгээнээс бүрдсэн.

Үндэсний хөгжлийн газрын хувьд 2018 онд дотоод шударга байдлын үнэлгээ 75.4 хувь, бодлогод оролцогчийн шударга байдлын үнэлгээ 75.7 хувиар тус тус үнэлэгдэж дунджаар 76.4 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн ба 2017 онтой харьцуулахад 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.5 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Хүний нөөцийг чадавхжуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт нийт үнэлгээгээр 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн үнэлгээтэй дүгнэгдлээ.

Газрын даргын 2018 оны А-28 тоот тушаалаар байгууллагын 2018 оны сургалтын төлөвлөгөөг батласан бөгөөд дотоод сургалтанд газрын нийт албан хаагчид, гадаад сургалтанд 34 албан хаагч буюу нийт албан хаагчдын 61 хувь нь хамрагдсан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор нийт 9 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон 19 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн тогтоосон. Мөн хагас бүтэн жилийн үр дүнг үнэлэн нийт 14 хүнийг салбарын шагналаар, нийт албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон. Тус шагнал урамшуулалд гүйцэтгэлээр 63,514.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөн албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах үүднээс Газрын даргын тушаалын дагуу ажлын хэсэг байгуулан зохион байгуулалтын арга хэмжээг авч, өрөө тасалгаанд засвар үйлчилгээ хийх, зарим техник тоног төхөөрөмжийг сайжруулах, нэмэгдүүлэх арга хэмжээг авсан.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж ажилласан байна.

2.6 Хэрэглэгчийн үнэлгээ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.1.4-д

“Захиргааны байгууллага нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг байгууллагын төсөвт тусган батлуулсан байна” гэж заасны дагуу 2018 онд шаардагдах зардлыг /9.8 сая төгрөг/ төсөвт тусган батлуулсан ба Газрын даргын 2018 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн А-155 “Хэрэглэгчийн үнэлгээ хийх тухай” тушаалыг батлуулсан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Засгийн газрын 2018 оны 129 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан судалгааны байгууллагуудаас үнийн санал авч харьцуулан Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эй Ай Си Эй” ХХ компаниар гүйцэтгүүлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалын хавсралт “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу удирдамжийг боловсруулан ажлын даалгаварт өгөгдсөний дагуу явцын тайланг 3 удаа авсан бөгөөд эцсийн тайланг 2018 оны 11 дүгээр сард багтаан хүлээн авсан. Тайланг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулан гэрээг дүгнэсэн.

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 19-29 насныхан 37.5 хувь, 30-39 насныхан 25.9 хувьтай хамрагдсан бол нийт оролцогчдын 36.6 хувь нь 40-өөс дээш насныхан байгаа нь хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд бүх насны төлөөллүүд хамрагдсан байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 46.7 хувь буюу дийлэнх нь төрийн байгууллагын албан хаагч, 14.4 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 10.4 хувь нь хувийн байгууллагад ажил эрхэлж байна.


Судалгаанд нийт 55 ААНБ-ын төлөөлөл хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 34, орон нутгийн 21 байгууллага байна. ААНБ-ыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 80 хувь буюу гуравны хоёр нь төрийн, 16.4 хувь нь хувийн, 3.6 хувь нь орон нутгийн өмчийн байгууллага байна. Судалгаанд хамрагдсан ААНБ-ууд нь ҮХГ-тай үндсэн 6 чиглэлээр хамтран ажилласан байна. ААНБ-ын 54.5 хувь буюу хоёрны нэг нь сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан, 20 хувь нь тус байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдсан, 10.9 хувь нь концессын гэрээгээр хэрэгжиж буй төслийн хүрээнд хамтран ажилласан байна. Үүнээс харахад төрийн байгууллагууд нь дийлэнхдээ шинэ мэдээ, мэдээлэл авах, бодлогын баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг бол хувийн хэвшлийн байгууллагууд нь концессын гэрээгээр хийгдэж буй төслийн тендер шалгаруулалт, гэрээт ажлыг гүйцэтгэгч, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллаж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

ҮХГ-ын хэрэглэгчийн үнэлгээг 4 бүлэг үзүүлэлтийн хүрээнд үнэлүүлсэн. Үүнд:

1. ҮХГ-ын талаарх ойлголт, мэдлэг
2. ҮХГ-ын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үнэлгээ
3. ҮХГ-ын байгууллагын үйл ажиллагааны талаарх ойлголт мэдлэг

4. ҮХГ-ын үйлчилгээний чанар хүртээмж(ААНБ)/ Концессын төслийн үнэлгээ (Иргэд) гэсэн байдлаар авсан бөгөөд Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжид заасан үнэлгээний дүн тооцох аргачлалын дагуу салбар, чиг үүргийн дундаж үнэлгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээний дунджаар тооцож гаргалаа.

Үндэсний хөгжлийн газрын талаарх ойлголт мэдлэг дунджаар 3.2, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үнэлгээ 3.3, байгууллагын үйл ажиллагаа 3.1, концессын төсөл 4.0 бөгөөд нийт салбар, чиг үүргийн дундаж үнэлгээ $(3.2+3.3+3.1+4.0/4)$ 3.4 буюу хувьчилбал 47.6 хувь байна.



Мөн үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын ёс зүй, байгууллагын орчны үнэлгээг нийслэл болон орон нутаг гэсэн ангилалаар гаргасан бөгөөд дундаж үнэлгээ 3.2 буюу 19.2 хувь байна.

Тус судалгаагаар байгууллагад өгсөн хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ 3.3 оноо буюу 66.8 хувийн үнэлгээг авсан. /Тайланг хавсаргав./

3.ДҮГНЭЛТ

Газрын үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүн

Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
		Хувь	Оноо /0-5/
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100 хувийн биелэлттэй- 8 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй- 3 арга хэмжээ 40 хувийн биелэлттэй- 5 арга хэмжээ 0 хувийн биелэлттэй- 2 арга хэмжээ Үнэлэх боломжгүй - 1 арга хэмжээ 67.2 хувь	3.36
	2.Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	үнэлгээгүй	-
	3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	100 хувийн биелэлттэй- 48 заалт 70 хувийн биелэлттэй- 24 заалт	

	биелэлт	30 хувийн биелэлттэй- 14 заалт Хугацаа болоогүй- 12 заалт 80.2 хувь	4.01
	4.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	2018 оны жилийн эцсийн байдлаар явцын мэдээ хүргүүлсэн. Үнэлгээгүй.	-
	5.Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт	100 хувийн биелэлттэй- 3 төсөл 100 хувь	5
Байгууллагын үйл ажиллагаа	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	100 хувийн биелэлттэй-162 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй- 27 арга хэмжээ 30 хувийн биелэлттэй- 17 арга хэмжээ 0 хувийн биелэлттэй – 1 арга хэмжээ 89.9 хувь	4.495
	2. Ил тод байдлын үнэлгээ	Үйл ажиллагааны ил тод байдал –100 хувь Хүний нөөцийн ил тод байдал – 80 хувь 90 хувь	4.5
	3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	Үнэлгээ гараагүй байна.	-
	4. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	Хүний нөөцийг чадавхжуулах – 100 хувь Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах – 100 хувь 100 хувь	5
	5.Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ /2018 он/	76.4 хувь	3.82
	6.Хэрэглэгчийн үнэлгээ	Салбар, чиг үүргийн үнэлгээ - 47.6 % Үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ - 19.2 % 66.8 хувь	3.34
Ерөнхий үнэлгээ		4.19	

Газрын 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.5 заалтын дагуу үнэлсэн бөгөөд 8 үзүүлэлтээр дүгнэхэд ерөнхий үнэлгээ **83.8** хувь буюу **4.19** оноотой үнэлэгдлээ.

Хавсралтаар хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт /хавсралт 1/, байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт /хавсралт 2/, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт /хавсралт 3/-ийг тайлагнаж байгаа ба

бодлогын баримт бичиг болон тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөрийн биелэлтийг тухай бүр /журамд заасан хугацаанд/ хүргүүлсэн болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын зорилтын хэрэгжилтээс 5 арга хэмжээ “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй, 2 арга хэмжээ үр дүнгүй, хууль тогтоомжийн биелэлтээс 14 арга хэмжээ “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй үнэлэгдсэн тул гүйцэтгэлийг сайжруулах талаар анхаарч, төлөвлөгөөтэй, идэвх санаачлагатай ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

Мөн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд 27 арга хэмжээ хэрэгжих шатанд буюу 70 хувь, 17 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ хэрэгжээгүй үнэлэгдсэн нь зорилт, арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитоор төлөвлөх, төсөвтэй уялдуулах, төлөвлөсөн хугацаандаа, арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах, төлөвлөгөөт ажлуудын биелэлтийг улирал бүр тооцон ажиллаж байх шаардлагатайг харуулж байна.

Цаашид, шинээр батлагдах бодлогын баримт бичиг, Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөхдөө арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бодит боломж, санхүүжилт, гарах үр дүнг харгалзан санал боловсруулж, батлуулж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

2019.02.20

ХШҮДАХ